



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/369

Мандалговь

Бог малын мялзан өвчний тархалтын
хүрээг тогтоох, хяналт, тандалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1, 15.6.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчин бүртгэгдсэн болон сэжигтэй хил залгаа сумдад зохион байгуулж буй арга хэмжээнд хяналт, тандалтын ажлыг зохион байгуулсугай.

2. Тандалтын арга хэмжээнд зарцуулагдах шатахууны зардал болох 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

3. Тандалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (И.Жавхлант), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очирт)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.АНХБАЯР

4822111202